СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 20 өдөр Дугаар А/85 Сүхбаатар сум

Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх комисс байгуулах, комиссын ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", Монгол Улсын Хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.2, 50.1.5, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн гэрээний 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2000 оны хэлэлцээрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх комисс"-ын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Шаардлагатай зардлыг орон нутгийн төсөвт суулгахыг хилийн сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын орлогчид, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргад, журмыг үйл ажиллагаанд мөрдөн ажиллахыг хилийн сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ш.ОРГИЛ

Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар
сарын 20- ны өдрийн захирамжийн
А/85 нэгдүгээр хавсралт

"ХУЛГАЙЛАГДСАН БОГОН БЭЛЧЭЭРЭЭР УЛСЫН ХИЛ ДАВСАН МАЛЫГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ, БУЦААН ӨГӨХ КОМИСС"-ЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:	-Сумын Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	-Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүдэд:	-Монгол Улсын Сэлэнгийн хэсгийн Хилийн бүрэн эрхт төлөөлөгчийн туслагч
	-Багийн Засаг дарга нар
	-Сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн дарга
	-Цагдаагийн хэсгийн мөрдөгч
	-Мал эмнэлгийн ажилтан
	-Орчуулагч
	-Малын эзэн

Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар
сарын 20- ны өдрийн захирамжийн
А/85 хоёрдугаар хавсралт

"ХУЛГАЙЛАГДСАН БОЛОН БЭЛЧЭЭРЭЭР УЛСЫН ХИЛ ДАВСАН МАЛЫГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ, БУЦААН ӨГӨХ КОМИСС"-ЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх комисс /цаашид комисс гэх/-ын ажлыг эрчимжүүлж, хил дамнан мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, таслан зогсооход журмын зорилго оршино.

1.2.Монгол Улсын болон хил залгаа улсын нутаг дэвсгэрээс хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх комиссын бүрэлдэхүүний эрх, үүрэг, ажиллах журам, мэдээ, мэдээлэл солилцох асуудлыг Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2000 он /Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх хамтарсан комиссын ажиллах журам/-ын хэлэлцээр болон энэхүү журмаар зохицуулна.

1.3.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно.

1.3.1."хил орчмын нутаг дэвсгэр" гэж хил залгаа улстай хиллэж байгаа сум, хошууны нутаг дэвсгэрийг;

1.3.2."хил орчмын оршин суугч" гэж хил орчмын нутаг дэвсгэрт байнга оршин суух бүртгэлтэй иргэнийг;

1.3.3."хил дамнан хулгайлагдсан мал" гэж Монгол Улсын болон хил залгаа улсын иргэдийн малыг гэмт хэрэгтэн хууль бусаар улсын хил давуулан хулгайлсныг;

1.3.4."бэлчээрээр улсын хил давсан мал" гэж бэлчээрээр болон байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас хил давсан малыг;

1.3.5."хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах" гэж хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу хил дамнан хулгайлагдсан болон хил давсан малыг олох зорилгоор талуудын хамтарсан комисс мэдээ, мэдээлэл солилцож, хил орчмын нутаг дэвсгэрт хамтарсан эрлийн ажиллагаа зохион байгуулахыг;

1.3.6."хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг буцаан өгөх" гэж хамтарсан комисс эрлийн үр дүнд олдсон мал таниулах, хүлээлцэх, улсын хил нэвтрүүлэх үйл ажиллагааг;

1.3.7."эрх бүхий байгууллага" гэж Монгол Улс, Оросын Холбооны Улсын хилийн бүрэн эрхт төлөөлөгч, түүний бүрэлдэхүүнийг;

1.3.8."хил хамгаалах байгууллага" гэж хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, хилийн боомт болон боомт бус газраар улсын хилийг хялбарчилсан журмаар хувь хүн, хуулийн этгээдийг хил нэвтрүүлэх, улсын хил хамгаалалтыг удирдан, зохион байгуулах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбарыг;

1.3.9."улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж" гэж хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зорилт бүхий саад /өргөст торон, төмөр/, тор, хянах зурвас, зам гүүр, хянах цамхаг, холбоо, дохиолол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон бусад байгууламжийг хэлнэ.

1.4. Тавигдах шаардлага

1.4.1.Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль, тогтоомжийг дагаж, мөрдөх;

1.4.2.Дипломат ёсыг сахиж, хил залгаа улсын ёс заншлыг хүндэтгэх;

1.4.3.Эрлийн тогтоосон журмыг сахих;

1.4.4.Аюулгүй байдлаа хангах;

1.4.5.Харилцан зөвшилцөх

1.5.Сэлэнгэ аймгийн "Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх комисс" дараах тохиолдолд Оросын Холбооны Улсын талтай хамтран ажиллана.

1.5.1.Хил дамнан мал хулгайлагдсан

1.5.2.Бэлчээрээр мал улсын хил давж, хил залгаа улсын нутгийн гүнд нэвтэрсэн;

1.5.3.Харилцан, мэдээ, мэдээлэл солилцох;

1.5.4.Ажлын уулзалт зохион байгуулах, туршлага солилцох.

1.6.Сэлэнгэ аймгийн хил орчмын нутаг дэвсгэрт зохион байгуулагдаж байгаа талуудын хамтарсан комиссын үйл ажиллагаатай холбогдолтой зардал /байр, хоол, шатах тосолох материал, бусад зардал/-ыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

Хоёр.Комиссын бүрэлдэхүүний үүрэг

2.1.Комиссын даргын үүрэг

2.1.1.Комиссын бүрэлдэхүүнийг удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

2.1.2.Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх хамтарсан комисс ажлын нөхцөл байдал, үр дүнг аймгийн Засаг даргад танилцуулах;

2.1.3.Хамтарсан комиссын хамтын ажиллагаа, мэдээ мэдээлэл солилцох асуудлыг зохион байгуулах;

2.1.4.Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, хил залгаа улсын талаас хүлээн авах, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.1.5.Улсын хилээр нэвтрэх үед комиссын бүрэлдэхүүнийг иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах бичиг баримттай нэвтрүүлэх;

2.1.6.Хил орчмын нутаг дэвсгэрт малчдыг малаа хариулгатай байлгах арга хэмжээ авч, гурвалсан гэрээ /багийн засаг дарга, хилийн салбарын захирагч, малчин/ байгуулах;

2.1.7.Комиссын үйл ажиллагаатай холбогдох зардлыг төсөв /хилийн аймаг, сумын төсөвт улсын хамгаалалтад зориулсан нэмэгдэл зардал/-т тусгах.

2.2.Комиссын орлогч дарга

2.1.2.Комиссын даргыг эзгүйд "Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх комисс"-ын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

2.1.3.Мал бүхий иргэдэд хил дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;

2.1.4.Комиссын ажиллах журмын хэрэгжилт, хамтарсан комиссын ажлын үр дүнг комиссын даргад танилцуулах;

2.3.Хилийн сумдын багийн Засаг дарга

2.3.1.Багийн малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж, гишүүнчлэлийн дэлгэрэнгүй судалгааг хөтлөх

2.3.2.Бод малыг тоолох, имнэх, тамгалах ажлыг зохион байгуулж, малын нэгдсэн сангийн бүртгэл /данс, фото зураг/-д хамруулж, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих;

2.3.3.Хил орчмын нутаг дэвсгэрийн малыг хариулгатай байх арга хэмжээг авч, мал бүхий иргэдээс баталгаа гаргуулах;

2.3.4.Айл өрх, нөхөрлөлөөр мал сүргээ өдрийн цагт хоньчлон хариулдаг, шөнийн цагт манаатай байлгаж байгаа эсэхэд хяналт тавих;

2.3.5.багийн өдөрлөг, хурлын үед комиссын холбогдох хүмүүсийг оролцуулан хууль сурталчлах, мэдээлэл хийх;

2.3.6.Алслагдсан малын талаарх мэдээллийг хилийн анги, салбар, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэж, бүртгэлд авах.

2.4.Хилийн бүрэн эрхт төлөөлөгчийн туслагч

2.4.1.Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малын талаар мэдээлэл авагдсан үед Хилийн бүрэн эрхт төлөөлөгч, орлогч нарт мэдэгдэж, хамтарсан комиссын даргад мэдээлэл дамжуулах, хүлээн авах холбоо барихад дэмжлэг үзүүлэх;

2.4.2.Хамтарсан комиссын бүрэлдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;

2.4.3.Хилийн болон хил орчмын дэглэмийн биелэлтийг сахиулах арга хэмжээг авах;

2.4.4.Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малын зөрчлийн асуудлаар комиссын даргад танилцуулах;

2.4.5.Хил орчмын нутаг дэвсгэрт оршин сууж буй малчид, сум багийн Засаг даргатай хамтран ажиллаж, малаа хариулгатай байлгах талаар гурвалсан гэрээ байгуулах.

2.5.Хэсгийн мөрдөгч

2.5.1.Хил дамнасан малын хулгай, гэмт хэрэгт холбогдсон болон холбогдож болзошгүй иргэдийн судалгааг комиссын удирдлага, холбогдох байгууллагад танилцуулах;

2.5.2.Хил орчмын нутаг дэвсгэрийн ард иргэд, малчдад хил дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах;

2.5.3.Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малын эзэн холбогдогчийг тогтоох;

2.5.4.Алдагдсан малын талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах.

2.6.Мал эмнэлгийн ажилтан

2.6.1.Хил орчмын нутаг дэвсгэрт гарсан малын гоц халдварт өвчний талаар шуурхай мэдээлэх;

2.6.2.Хулгайлагдсан болон бэлчээрээр хил давсан малыг таниулж, хүлээлцэх үед малд үзлэг хийж, шаардлага гарвал малыг түр тусгаарлах, нядлах буюу устгах.

2.6.Малчин болон мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага

2.7.1.Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давж алдагдсан малын талаар хилийн анги, салбар, хэсгийн мөрдөгч, багийн Засаг даргад нэн даруй /малын тоо, төрөл, нас, хүйс, им тамга, зүс болон алдагдсан хугацаа/ мэдэгдэж, бүртгүүлэх;

2.7.2.Малыг таниулах үед малаа үнэн зөв таних, өөрийн мал болохыг нотолсон холбогдох баримт бичгийг бүрдүүлэх

2.7.3.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үүргээ хэрэгжүүлэх

Гурав.Хил дамнан мал хулгайлагдсан болон бэлчээрээр мал улсын хил даван нутгийн гүнд нэвтэрсэн үеийн комиссын ажиллагаа

3.1.1.Мал бүхий иргэд малаа алдсан, бэлчээрээр улсын хил давсан талаарх мэдээллийг сум, багийн Засаг дарга, хилийн анги, салбарт нэн даруй мэдэгдэнэ.

3.1.2.Хамтарсан комиссын дарга нь Хилийн бүрэн эрхт төлөөлөгчөөр дамжуулан хил залгаа улсын хамтарсан комиссын даргад мал хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан хэргийн талаар албан бичиг /малын тоо, төрөл, нас, хүйс, им тамга, зүс болон алдагдсан хугацаа, газар зэрэг эрэл явуулахад шаардагдах өгөгдөхүүнүүдийг агуулна/-ээр мэдэгдэнэ.

3.1.3.Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч, Оросын Холбооны Улсын Буриад Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын орлогч дарга нар хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малын талаарх мэдээллийг факсан холбоогоор нэн даруй солилцоно.

3.1.4.Нэг талын нутаг дэвсгэрээс мал хулгайлагдан хил давж негөө талын нутаг дэвсгэрт орсон тохиолдолд хил залгаа улсын Хилийн бүрэн эрхт төлөөлөгчдөд шуурхай мэдэгдэнэ.

3.1.5.Хилийн бүрэн эрхт төлөөлөгч хамтарсан комиссуудад мэдээлэл хүлээн авах, дамжуулах, холбоо барихад туслалцаа үзүүлнэ.

3.2.Хил нэвтрэх үед:

3.2.1.Нутаг дэвсгэрт нь мал хулгайлагдсан болон бэлчээрээр орж ирсэн талын хамтарсан комиссын удирдагч мэдээлэл хүлээн аваад малын нэг талын эрэл үр дүнд хүрээгүй тохиолдолд малын хамтарсан эрлийг зохион байгуулахын тулд хамтарсан комиссын гишүүдийн уулзалт зохион байгуулна.

3.2.2.Хамтарсан комиссын бүрэлдэхүүн эрэл явуулах, мал таниулах шаардлагатай газарт хувийн баримт бичигтэйгээр тогтоосон хугацаанд бэлэн байна.

3.2.3.Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх комиссын бүрэлдэхүүнийг "Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийн хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн Газар, Оросын холбооны Улсын Засгийн Газар хоорондын 1994 оны хэлэлцээр"-ийн 11 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын "в", "д" хэсэг, 13 дугаар зүйлийн 1, 2 дугаар заалтын дагуу талуудын Хилийн бүрэн эрхт төлөөлөгч нар хялбаршуулсан журмаар улсын хил нэвтрүүлнэ.

3.2.4.Талуудын комиссын бүрэлдэхүүн хүчин төгөлдөр үнэмлэхээр хоёр улсын хилийг мөр хүлээлцсэн чиглэлээр буюу алдагдсан мал байж болох чиглэлээр нэвтэрнэ.

3.3.Хамтарсан эрэл зохион байгуулахад:

3.3.1.Нэг талын нутаг дэвсгэрээс мал хулгайлагдан хил давж нөгөө талын нутаг дэвсгэрт орсон тохиолдолд хамтарсан шалгалт явуулж, алдагдсан малыг нөгөө талын нутаг дэвсгэрт хамтран эрэн сурвалжилна.

3.3.2.Хил дамнан хулгайлагдсан болон бэлчээрээр хил давсан малыг эрэн сурвалжлах бүсийн гүн нь талуудын хил орчмын нутаг дэвсгэрээр хязгаарлагдана.

3.3.3.Хамтарсан комиссын уулзалтаар малын эрлийг зохион байгуулахдаа шаардлагатай мэдээллийг судалж, хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах талаар харилцан тохиролцож, шийдвэр гаргана.

3.3.4.Шийдвэрт доорх зүйл тусгагдана. Үүнд:

-Эрэлд оролцох бүрэлдэхүүн, уналга, тээврийн хэрэгсэл, тэдгээрийг улсын хилээр хэзээ, хаагуур, хэрхэн нэвтрүүлэх

-Эрлийн ажиллагаанд нөгөө талын комиссоос ямар хүмүүсийг оролцуулах

-Эрэл явуулах журам

-Эрлийг явуулах хугацаа хилээр буцаж нэвтрэх журам болон бусад шаардлагатай асуудлуудыг тусгасан байна.

3.3.5.Талуудын хамтарсан комиссыг тухайн хил орчмын нутгийн засаг захиргааны нэгжийн төлөөлөгч удирдана. Хамтарсан комиссын ажил нь хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малын эрлийг нутаг дэвсгэр дээрээ зохион байгуулж байгаа тэр улсын комиссын удирдагчийн удирдлага дор явагдана.

3.3.6.Комисс нь хилийн асуудлаар мөрдөгдөж байгаа гэрээ хэлэлцээр тухайн улсын хууль тогтоомжийг хүндэтгэн биелүүлнэ. Тухайн нутаг дэвсгэрийн комисс нь нөгөө талынхаа комиссын аюулгүй байдлыг хангана.

3.3.7.Эрэл нааштай үр дүнд хүрээгүй тохиолдолд хамтарсан комисс нь эрэл эхэлснээс хойш 48 цагийн дараа түүнийг зогсоох буюу цаашид үргэлжлүүлэх шийдвэр гаргаж, анхны цагийн байдал, нэмэгдэл нөхцөл байдлуудыг нөгөө талдаа хүлээлгэн өгнө.

3.3.8.Комиссын амь насны аюулгүй байдалд занал хийх, эрлийн ажиллагаанд саад бэрхшээл учруулбал нөгөө талын нутагт ажиллаж буй комисс бие даан эрлийн ажиллагааг зогсоох эрхтэй бөгөөд болсон асуудлын талаар Хилийн төлөөлөгчид нэн даруй мэдэгдэнэ.

3.4.Мал таниулж, хүлээлцэх үед:

3.4.1.Хамтарсан комиссын эрлийн үр дүнд олдсон малыг таниулахад Монгол Улсын талаас алдагдсан мал болохыг нотолсон холбогдох баримт бичиг /мал алдсан тухай цагдаагийн хэсгийн мөрдөгчид тэмдэглүүлсэн тодорхойлолт, сумын засаг даргын албан бичгээр албажуулсан малын зүсэм, нас хүйс, им тамгын бүртгэл, жилийн эцсийн тооллогын баталгаажсан бүртгэл, малын баримтжуулсан фото зураг/-ийг бүрдүүлсэн байна.

3.4.2.Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан мал мөн болохыг нотолсон баримт бичгийн дагуу нэг бүрчлэн тулгалт хийж, таниулах ажиллагааг явуулна.

3.4.3.Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан мал болох нь тогтоогдвол малын эрлийг өөрийн нутаг дэвсгэрт явуулсан хамтарсан комиссын хэсэг нь уг малыг илрүүлсэн, өвчтэй мал амьтдыг хорио цээрийн зайлшгүй шаардлагаар тогтоон барьж байх явцад урьдчилан сэргийлэх болон малын тахлын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлснийг нотолсон баримт бичиг үйлдэнэ.

3.4.4.Хамтарсан эрлийн үр дүнд олдсон малыг улсын хилээр нэвтрүүлэн өгөх ажлыг талуудын Хилийн бүрэн эрхт төлөөлөгчдийн тохиролцон тогтоосон баримт бичгийн дагуу Хилийн бүрэн эрхт төлөөлөгчийн туслагч, мал эмнэлгийн мэргэжилтэн гүйцэтгэнэ.

3.4.5.Хил давсан малыг хүлээн авах, хүлээлцэх баримт бичгийг Монгол, Орос хэлээр үйлдэнэ.

3.5. Хориглох зүйл

3.5.1.Хамтарсан комиссын бүрэлдэхүүн уулзалтын товлосон хугацаанаас хоцрох;

3.5.2.Дипломат ёсыг сахихгүй, зүй бус зан авир гаргах;

3.5.3.Мал таниулах үед нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, малаа буруу таних;

3.5.4.Согтууруулах ундаа хэрэглэх

3.6 Хүлээлгэх хариуцлага

3.6.1.Хамтарсан комиссын үйл ажиллагаанд хангалтгүй оролцсон, бэлтгэл ажлыг хангаагүй төрийн албан хаагчдад комиссын даргын саналыг үндэслэн хуулийн дагуу хариуцлага тооцно.

3.6.2.Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах буцаан өгөх хамтарсан комиссын үйл ажиллагаанд амжилт гаргасан төрийн алба хаагчийг аймгийн Засаг даргын шийдвэрээр шагнаж урамшуулна.